

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА  
/2020 оны жилийн эцсийн байдлаар/**

**НЭГ. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол Улсын Хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, УИХ болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан тогтоол, шийдвэр зүйл, заалтуудын биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийн барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг 2020 оны жилийн эцсийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Эрх зүйн актын биелэлтийн хувийг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон ашигласан болно.

Эрх зүйн актын зүйл, заалтын агуулга жил бүр давтагдах шинж чанартай бол тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр тооцож гаргалаа.

**ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН**

**3.1. Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтын тоо**

Барилга, хот байгуулалтын яаманд 2020 оны жилийн эцсийн байдлаар ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд байршуулсан БХЯ-ны үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Улсын Их Хурал, УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар нийлсэн нийт 131 тогтоол, шийдвэрийн 214 заалтыг хяналтад авч журмын заалтуудыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

**3.2. Үнэлгээний дундаж дүн**

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг 1-р хүснэгтэд үзүүлэв. Хүснэгт 1-ээс харахад хяналтад авсан 214 заалтын 194 нь бүрэн биелэгдсэн буюу 100 хувийн үнэлгээтэй, 8 заалт хэрэгжих шатанд буюу 70 хувийн үнэлгээтэй, 1 заалт хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн үнэлгээтэй, хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй 11 заалттай дүгнэгдсэн ба биелэлтийн дүн дунджаар 98,4 хувьтай үнэлэгдэв.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэгдсэн дүн  
/2020 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

Бүгд		Шийдвэрийн төрлөөр									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	131	8	19	7	1	52	33	2	6	3	
Заалтын тоо /жилийн эцсийн байдлаар/	214	22	30	10	1	77	50	15	6	3	
Үнэлгээ	Биелсэн /100%/	194	20	25	10	-	72	44	14	6	3
	Хэрэгжих шатанд /70%/	8	-	2	-	1	3	2	-	-	-
	Хэрэгжилт хангалтгүй /30%/	1	-	-	-	-	1	-	-	-	-
	Хугацаа болоогүй /үнэлэх боломжгүй	11	2	3	-	-	1	4	1	-	-
Үнэлгээ /жилийн эцсийн байдлаар/	98.4%	100%	97,7%	100%	70%	98,6%	99,3%	100%	100%	100%	

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

4.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт дунджаар 98,4 хувьтай буюу тодорхой үр дүн гарч 2019 оны жилийн эцсийн үнэлгээтэй харьцуулахад 4,5 хувиар өссөн хэрэгжилттэй байна.

4.2. Хяналтад авч хэрэгжилтийг тооцсон хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс хэрэгжих шатандаа буюу 70 хувийн хэрэгжилттэй 8 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалт /хүснэгт 2-р үзүүлж хавсаргав/

4.3. Хяналтад авч хэрэгжилтийг тооцсон хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс гадны хүчин зүйл буюу өөр төрийн байгууллагын эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх болон дэлхий

нийтэд тархаад байгаа цар тахал, онцгой нөхцөл байдлаас шалтгаалж хугацаа болоогүй болон үнэлэх боломжгүй 11 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалт /хүснэгт 3-р үзүүлж хавсаргав/

4.4. Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, ҮАБЗ-ийн зөвлөмж, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол шийдвэрийн барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан нийт 214 заалтын 91 заалт 2020 онд, 52 заалт 2019 онд, 30 заалт 2018 онд, 24 заалт 2017 онд, 11 заалт 2016 онд, 2010-2015 онд 6 заалт тус тус батлагдсан байна. Барилга, хот байгуулалтын салбарт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилтай холбоотой гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа харьцангуй шуурхай хийгдэж байгаа нь жилийн ажлын явц, үр дүнгээс харагдаж байна. /Хүснэгт 4-р үзүүлж хавсаргав/

4.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авах, танилцуулах, хэрэгжилт тооцох, тайлагнах үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

4.6. Хяналтад авч хэрэгжилтийг тооцсон хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс 2019 оны жилийн эцэс, 2020 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг тооцоход хэрэгжилт хангалтгүй байсан тогтоол шийдвэрийн заалт 2020 оны жилийн эцсийн байдлаар бас дахин хэрэгжилт хангалтгүй байна.

Үүнд:

- ЗГ-ын тогтоол 2019\_30. Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай / 2019-01-16 / 2. Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж 2019 оны III улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд оруулан шийдвэрлүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгасгай.

Хэрэгжилт: БХБ-ын Сайд, аймгийн Засаг даргатай байгуулах гэрээнд Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2020 онд багтаан боловсруулах талаар тусгасан. /ХБГХБХЗГ/

## ТАВ. ЗӨВЛӨМЖ

5.1. ХШҮ-ний нэгдсэн дүнгээр хангалтгүй хэрэгжсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг газар, хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусгаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг;

5.2. УИХ-ын “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2016 оны 34 дүгээр тогтоолын 1.2-т заасан ажлыг эрчимжүүлж, 9 аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг хийхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийвэрлүүлэх талаар анхаарч ажиллах;

5.3. Хуулийн хэлтэс хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох дээд шатны байгууллагаас ирсэн даруйд бүртгэл хөтөлж, холбогдох газар, хэлтэсүүдэд танилцуулж хяналтанд авах;

5.4. Газар, хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллах гэсэн заалтыг хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгт тусгаж, хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах албан хаагчийг томилон, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь арга хэмжээ болгож тусган, биелэлтийг тооцож ажиллахыг;

5.5. Нэг удаагийн шинж чанартай, хугацаа дууссан, үйл ажиллагаа нь өөр төрийн захиргааны төв байгууллагад шилжсэн болон цаашид хэрэгжих боломжгүй болсон тогтоол шийдвэрүүдийг тухай бүрт нь хяналтаас хасуулах тал дээр анхаарч, ХШҮДАГ-тай хамтарч ажиллаж хэвшихийг яамны газар, хэлтсийн дарга нарт тус тус зөвлөмж болгож байна.

